



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс: (976-51) 26-74-68, http://www.mof.gov.mn

2019.04.29 № 6-1/2647

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Гомдол хянан үзсэн тухай

Танай газраас зарласан “Улсын мэдээллийн маягт нийлүүлэх” УБЕГ/201901001 дугаартай тендер шалгаруулалтын 2 дугаар багцад оролцсон “Соёмбо принтинг” ХХК-аас гаргасан гомдлыг холбогдох материалд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид хууль гэх/-ийн 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсэгт заасны дагуу хянан үзлээ.

“Соёмбо принтинг” ХХК гомдолдоо хамгийн бага үнийг санал болгож ирүүлсэн байхад “Адмон принт” ХХК-ийг шалгаруулсан захиалагчийн шийдвэрийг шалгуулахыг хүсжээ.

Захиалагч тендер шалгаруулалтын 2 дугаар багцад оролцсон “Соёмбо принтинг” ХХК-ийн ирүүлсэн тендерээс татгалзсан мэдэгдэлд ямар үндэслэлээр татгалзсан эсэхийг тодорхой заагаагүй нь хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт “Захиалагч ..... бусад тендерт оролцогч бүрд шалгараагүй үндэслэлийн хамт нэгэн зэрэг бичгээр мэдэгдэнэ.” гэж заасныг зөрчсөн байх тул багцын үнэлгээг дахин хийхийг хуулийн 55 дугаар зүйлийн 55.3.3-т заасны дагуу мэдэгдье

Хуулийн 55 дугаар зүйлийн 55.4 дэх хэсэгт заасны дагуу тендер шалгаруулалтын үйл ажиллагааг түр түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болсныг анхаарна уу.

Хувийг: “Соёмбо принтинг” ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

С.НАРАНЦОГТ



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс: (976-51) 26-74-68, http://www.mof.gov.mn

2019 ОЧ 14 № 6-1/2302

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Гүйцэтгэгч сонгох ажиллагааг  
түр түдгэлзүүлэх тухай

Танай байгууллагаас зарласан “Улсын мэдээллийн маягт нийлүүлэх” УБЕГ/201901001 дугаартай тендер шалгаруулалтад оролцсон “Соёмбо принтинг” ХХК-иас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид “хууль” гэх/-ийн 55 дугаар зүйлийн 55.1-д заасны дагуу гомдол гаргаад байна.

Хуулийн 55 дугаар зүйлийн 55.4-т заасны дагуу дээрх тендер шалгаруулалтын гүйцэтгэгч сонгох ажиллагааг түр хугацаагаар түдгэлзүүлж байна.

Гомдлыг хянан шийдвэрлэхэд шаардлагатай дараах баримт бичгүүдийг 2019 оны 04 дүгээр сарын 19-ний дотор ирүүлнэ үү. Үүнд:

1. Гэрээ байгуулах эрх олгосон захиалагчийн шийдвэр;
2. Тендерийн баримт бичиг;
3. Тендерт оролцогчдын ирүүлсэн тендер;
4. Тендерийн нээлтийн тэмдэглэл;
5. Захиалагчийн үнэлгээний хорооны тушаал;
6. Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, шийдвэр;
7. Тендерт оролцогчид болон бусад байгууллагуудтай харилцсан бичиг;
8. Гэрээ байгуулах эрх олгох болон шалгараагүй мэдэгдлийг тендерт оролцогч нарт хүргүүлсэн талаарх нотлох баримт;
9. Холбогдох бусад баримт бичиг;
10. Гэрээ байгуулах эрх олгосон оролцогчид гомдол гарсан талаар мэдэгдсэн мэдэгдэл.

Гэрээ байгуулах эрх олгосон оролцогчид гомдол гарсан талаар мэдэгдэх, Захиргааны ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.15 дахь хэсэгт заасны дагуу гомдлыг хянах хугацаанд тендер шалгаруулалтын хүчинтэй байх хугацаа түр хугацаагаар зогсох болохыг үүгээр мэдэгдэж байна.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,  
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ГАЗРЫН  
ДАРГА

З.ЭНХБОЛД

